

Эмэгтэйчүүд ба Тэмбүү өвчин

Тэмбүү бол маш ноцтой халдварт өвчин бөгөөд Австралид улам бүр олон эмэгтэйчүүдэд тархсаар байна. Тэмбүүгийн талаар болон хэрхэн сэргийлэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай.



Тэмбүү нь маш ноцтой бэлгийн замаар дамжих халдвар /БЗДХ/ бөгөөд халдвартай хүнээс нөгөөд бэлгийн хавьтлын үеэр халдварлана.



15-44 насны эмэгтэйчүүдийн дундах халдварын тархалт улам ихэссээр байна

2016-2022 оны хооронд Австралид 15-44 насны эмэгтэйчүүдийн дундах тэмбүүгийн халдвар 158%-аар ихэссэн*.



Та тэмбүүгийн халдвар авснаа мэдэлгүй явж байж болно

Зарим хүмүүст ямар ч зовиургүй, халдвар авснаа мэдэлгүй явах тохиолдол байдаг. Тэмбүүгийн халдвар авснаа мэдэлгүй хамтрагчдаа тараах боломжтой.

Тиймээс та өөрөө болон бэлгийн хамтрагч тань тогтмол БЗДХ-ын бүрэн шинжилгээнд хамрагдахыг зөвлөж байна – ямар ч шинж тэмдэг илрээгүй ч гэсэн.

Хэрэв та тэмбүүгийн халдвар авснаа мэдвэл, бэлгийн хамтрагчдаа мэдэгдээрэй. Ингэснээр тэд ч мөн адил шинжилгээ өгч, эмчилгээ хийлгэх боломжтой болох бөгөөд дахин өөр хүнд юмуу танд буцаан халдвар тараахаас сэргийлэх боломжтой.



Тэмбүүгийн шинж тэмдэг хүн бүрт харилцан адилгүй байдаг

Хэрэв тэмбүүгийн халдвар авбал хамгийн түрүүнд илрэх шинж тэмдэг нь бэлэг эрхтэн, шулуун гэдэс болон ам орчмоор яр шархлаа гарах юм.

Цаашид халдвар удахаараа өөр шинж тэмдгүүд илэрч эхэлнэ. Жишээлбэл:

- Тууралт
- Арьсны гэмтэл сорви
- Тунгалгийн булчирхай хавдах
- Үс унах
- Булчин, үе мөчөөр өвдөх
- Толгой өвдөх
- Ядарч сульдах



Эмчлүүлэхгүй бол тэмбүү:

- Тархины халдвар
- Деменци – зөнөх өвчин
- Уушиг болон зүрхний дутагдал
- Хараагаа алдах
- Амь насаа алдахад хүргэж болзошгүй

*Australian Department of Health and Aged Care, (2023), National Notifiable Disease Surveillance System. Available at <https://nindss.health.gov.au/pbi-dashboard>



Тэмбүү урагт халдбалургийн амь насанд халтай

Хэрвээ та жирэмсэн ба тэмбүүгийн халдвартай бол урагт халдвар дамжих эрсдэлтэй.

Үүнийг төрөлхийн тэмбүү гэж нэрлэдэг бөгөөд:

- Зулбалт
- Амьгүй төрөлт
- Дутуу төрөлт
- Бага жинтэй нярай
- Төрсний дараа удалгүй нярай эндэх зэрэг үр дагаварт хүргэж болзошгүй

Төрөлхийн тэмбүү хүүхдэд эргэшгүй тархины болон эд эрхтний гэмтэл үүсгэж болно. Үүний улмаас хүүхэд өсөлт хөгжлийн хоцрогдолтой болж болзошгүй.

Зарим хүүхдэд өсөлт хөгжлийн хоцрогдол бүр хожуу илэрч, хожуу оношлогдох нь бий.



Тогтмол шинжилгээ хийлгэх нь танд ашиг тустай

Та ямар ч шинж тэмдэггүй байсан ч тогтмол БЗДХ-ын шинжилгээг өгч заншаарай. Ялангуяа жирэмсэн юм үү жирэмслэхээр төлөвлөж байгаа бол нэн чухал юм.

Тэмбүүгийн сорил нь жирэмсэн үед өгөх чухал тогтсон шинжилгээнүүдийн нэг.

Тэмбүүгийн халдвар хүн амын дунд ихсэж байгаатай холбоотойгоор төрөлхийн тэмбүүгээс сэргийлэхийн тулд жирэмсэн үед тэмбүүгийн сорилыг дор хаяж 2 удаа авдаг. Хэрэв халдвар авах магадлал өндөр байвал тэмбүүгийн өөр хэлбэрийн шинжилгээг авч магадгүй.

Эмч, эх баригч ба жирэмсний хяналтын эмнэлэгтээ хандан БЗДХ-ын бүрэн шинжилгээг (тэмбүүгийн сорил багтаасан) өгөөрэй.



Тэмбүүгийн эмчилгээ хялбар

Тэмбүүг эмчлэх хялбар. Эмийн бэлдмэл (ихэвчлэн тарилга хэлбэрээр) хэрэглэхэд халдвар устгах бөгөөд танд болон урагт аюулгүй.

Эмчилгээ дууссаны дараагаар эмчилгээний үр дүнг шалгахын тулд цусны шинжилгээ өгөх шаардлагатай.

Таны эмч болон бэлгийн эрүүл мэндийн мэргэжилтэн эмчилгээ, хяналтыг хийнэ.



Хэрхэн сэргийлэх вэ

Тэмбүүгээс сэргийлэх хамгийн оновчтой арга бол аюулгүй бэлгийн харилцааг эрхэмлэх юм:

- Шинэ бэлгийн хамтрагчтай болох үедээ үргэлж бэлгэвч хэрэглэх, ба чийгшүүлэгч/лубрикант ашиглахдаа бэлгэвчтэй хэрэглэхэд тохиромжтойг сонгон хэрэглэх (жишээ нь: усан болон силикон суурьтай).
- Бэлэг эрхтэн, шулуун гэдэс, ам орчим дээр нь яр гарсан, шархалсан хүнтэй бэлгийн харилцаанд орохоос зайлсхийх.
- Тогтмол БЗДХ-ын шинжилгээ (тэмбүүгийн сорилыг багтаасан) өгч хэвших.
- Халдварыг бусдад болон танд буцаан халдаахаас сэргийлэхийн тулд бэлгийн хамтрагч тань мөн адил тогтмол шинжилгээ өгч, шаардлагатай бол эмчилгээ хийлгэх хэрэгтэй.
- Хэрэв бэлгийн хамтрагчтайгаа холбоо барин, энэ талаар мэдээлэхэд таагүй байгаа бол www.letthemknow.org.au вэбсайт руу хандан зөвлөгөө авах юм үү GP эмч болон бусад эрүүл мэндийн ажилчидтай ярилцаарай.



QR кодыг уншуулж тэмбүү болон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг аваарай.